

Coming to terms with Buddhism

“Учирсан бүх зүйлд “баярлалаа” гэсэн талархалын үг хэлэх”

Та бүгд “баярлалаа” гэсэн үгийг хэр хэрэглэдэг вэ? Өдөрт ямар үед хэдэн удаа “баярлалаа” гэж хэлснээ санан бодоод үзсэн үү? Өдөр бүр завгүй өнгөрүүлж, зөвхөн нүднийхээ өмнөх зүйлд л автагдаж, орчин тойрноо үл тоомсорлож орхидог биш биз?

Бид бүгд өдөр бүр хүнээр түшиглүүлэн амьдардаг. Гэвч бид үүнийг мэдээжийн хэрэг мэт бодож талархдаггүй. Алдаж орхисон үедээ л тухайн зүйлийн талархалыг ойлгож, харамсдаг билээ.


Үглээ ээж, хүнд хэцүү зүйл л заадаг багш, ажлыг хянаж хардаг дарга гээд яршигтай хүн их байдаг. Яршигтай юм аа гэж бодох үе ч байдаг. Гэвч тэд яагаад тэгж байдгийг бодож үзсэн үү? Биднийг хөгжиж дээшлээсэй л гэж тэд зарим үед хатуу чанга хэлбэрээр хайраа илэрхийлдэг байна.

Мөн бидний орчин тойронд амь явахын тулд зайлшгүй хэрэгцээтэй болдог байгалийн баялаг байдаг.

Жишээлбэл, өдөр бүр амьсгалах агаар, амны цангааг тайлах ус, нарны дулаан элч, модны сүүдэр... Эдгээрийн нэг нь ч гэсэн алга болбол бид амьд явж чадахгүй.

Бас хүн амьдралдаа алдаж ч байдаг. Гэвч хүн бол хийсэн алдаанаасаа сургамж

хүртэж, амьдралаа дахиад засаад авч явах чадвартай. Учирч тохиолдсон бүх зүйлс нь биднийг хөгжүүлэн өсгөхийн тулд байдаг гэдгийг мэдэрвэл бүхий зүйлд талархах сэтгэл төрнө. Үнэхээр талархаж байвал түүнийгээ өөртөө хадгалгүй, “баярлалаа” гэсэн үгээр дамжуулья. “Баярлалаа” гэдэг үг нь хүний энэрэнгүй сэтгэлийг илэрхийлэх ганц хормын үг билээ. Ганцхан хормын ганцхан үгээр хүнд хүний энэрэнгүй дулаан сэтгэл дамжигдана. Энэ үг бол хэлж байгаа хүнийг ч, сонсож байгаа хүнийг ч ямар ч байдалд байсан ч инээмсэглэл төрүүлнэ. За, ингээд та бүгд ч энэ илбэ шиг үгийг өөрөөсөө хэлж үзвэл ямар вэ?



Хагивара даргад хандиваа өгч байгаа Уранбилэг охин

Монголын Их Бодисадва

Монголын Улаанбаатар хотын Сүхбаатар дүүргийн гишүүд өвчтэй хүүхдүүдийн гэрээр айлчилж, ном уншиж, бэлэг тараах үйл ажиллагаа явуулдаг байна.

Энэ үйл ажиллагаанд оролцдог нэгэн охин байдаг байна. Нэр нь Цэрэннадмидын Уранбилэг билээ. 10 настай. Тэрээр нэг удаа “Мөргөл үйлдэж, хандив өргөн сургаалыг бусдад танилцуулах үйл ажиллагаа бол их буянтай сайн зүйл” гэдгийг дуулаад өөрийнхөө карманыхаа мөнгөнөөс мөнгө цуглуулж эхэлсэн байна. Өвчтэй хүүхдүүдэд өчүүхэн ч гэсэн нэмэр болохсон гэсэн сэтгэлээр...

Тэгээд 1 сард Японоос ирсэн Олон Улсын Төвийн дарга Хагиварад өөрийнхөө цуглуулсан мөнгөө өрөвч, энэрэнгүйн сэтгэлтэй хамт өргөн барьсан байна.

Ийнхүү Улаанбаатарын салбарын жижигхэн биетэй бодисадва охин агуу их том нигүүлсэхүйн сэтгэлтэй Их Бодисадва байжээ.

“Юуны өмнө бусад хүмүүс” гэсэн сэтгэлээр

Рисшо Косей-Кайгын ерөнхийлөгч
Нивано Ничикоу



“О-Хиган” гэдэг юу вэ?

Энэ сард бид “о-хиган” гэдэг өвөг дээдэстээ зориулсан хаврын ёслолыг гүйцэтгэнэ. Япон хэл дээр илэрхийлэх энэ хаврын ёслолын үгийн утга нь эртний энэтхэг хэл дээр “барамид”, хятад хэл дээр мөн “барамид” гэж бичигдэж, гэгээрлийн ертөнцөд бол дээдийн байдалд хүрэх, төөрөгдлийн ертөнцөөс гэгээрлийн ертөнцөд орох гэсэн утгатай билээ.

Энэ ёслол нь эрт дээр үеэс Японд уламжлагдаж ирсэн үндэсний өвөрмөц ёс билээ. Энэтхэгт төрсөн буддын сургаалд анхнаас өвөг дээдсээ тахин шүтэх мөргөл байгаагүй гэж зарим хүмүүс ярьдаг. Гэвч биднийг төрүүлэн өсгөсөн бидний эцэг эх, эмээ өвөө, тэд нарын эцэг эх, бас түүний өмнөх эцэг эх гээд хязгааргүй олон өвөг дээдэстээ талархан мөргөж байх нь мэдээжийн хэрэг тул манай сургаалын нэгэн үзэл мөн билээ.

Өвөг дээдсээ судлан судлан, эцэст нь бүхний төрөл гарал нь нэгэн агуу их Амийс үүсдэг гэдгийг мэдсэн билээ. Ийм ч утгаар буддын сургаал бол өвөг дээдсээ шүтэн тахидаг шашин бөгөөд үүгээр бид мөн чанартаа нэгэн агуу их Амийс амилагдан амьдарч байгаа гэдгийг ухааран ойлгох ёстой юм.

зан чанараараа өөр өөр байдаг ч нэгэн агуу их Амьтай холбоотой байдгийн баталгаа юм. Хүнийг баярлуулж өөрөө баяртай байх явдал нь “бүх зүйлс нэгэн амийс амилагдаж, нэгэн амь мөн” гэсэн ухааралд хүргэдэг байна.

Өвөг дээдэстээ өргөх хамгийн дээд мөргөл

Хүнийг баярлуулах баяр баясгалан

Ёслолын цаг ойртохоор ихэнх хүмүүс өвөг дээдсийнхээ шарилыг эргэн тойрдог байна. Гэвч энэ ёслолын утгын дагуу бид зөвхөн өвөг дээдсээ ном уншиж мөргөхөөс гадна бас гэгээрлийн ертөнцөд ойртож байгаа тул аз жаргалд ойртож байгаа гэсэн утгатай билээ. Тодруулан хэлбэл, бид бодисадвагийн үйлээр дамжиж аз жаргалтай болдог байна. Бодисадвагийн үйл гэдэг нь хүнийг баярлуулах үйл буюу бусдын аз жаргалыг хүсэх үйл билээ. Үүний үндэс нь зургаан барамидад анх заасан хандив гэсэн үйлд байдаг. Хүнд эд зүйлс хандивлан өгснөөр нигүүлсэхүйн сэтгэл, хүнийг хайрлан бодох сэтгэл төрдөг байна.

Бид заавал өөрийгөө бусадтай харьцуулан үзэж, хүний ялгах зуршилтай байдаг. Гэвч бид хүнийг баярлуулснаар өөрсдөө ч мөн баярладаг билээ. Энэ нь бид бусадтай гаднах үзэмж, өвөрмөц

Сударт “Өөрөө гэгээрэлд хүрээгүй ч, бусад хүнийг түрүүлэн гэгээрэлд хүргэж өг” гэсэн сургаал байдаг байна. Өөрөөсөө илүү бусдыг эхлээд гэгээрлийн замд хөтлөн оруулахыг бас бодисадвагийн сэтгэлгээ гэдэг байна. Энэ бол гишүүд бидний “өөрөөс илүү бусад” гэсэн сэтгэлгээтэй яг адил санаа билээ. Өөрийгөө орхиж, юуны өмнө бусдыг сургаалын замд оруулж аз жаргалтай болгох-энэ бол хүнийг бодох, нигүүлсэхүйн сэтгэлийн илэрхийлэл бөгөөд чухам үүнд л хүний баяр баясгалан, амьдралын учир утга оршдог байна.

Бидний өвөг дээдэс хамгийн их баярлах зүйл бол бид бусдыг хайрлан баярлуулж амьдрах явдал билээ. Хаврын энэ ёслолоор дамжин бүгд юуны өмнө бусад хүний төлөө гэсэн сэтгэлээ хөгжүүлэн дэвшүүлье.

“Косэй” 3 сарын дугаараас

Косэйкайгийн сургаалын ачаар олон хүнд аз жаргал өгөх

Сахалин хозагийн эрхлэгч Мүто Айко

“Олон аз жаргалтай гэр бүл төрөөсэй” гэсэн хүслээр би Оросын Сахалин дахь салбарын үйл ажиллагааг явуулдаг. Южный Сахалин хотод одоогоор 50 гаруй гишүүд бий.

Сахалинд анх сургаал нэвтэрсэн нь 1992 он юм. Тэр үед Саппоро хотын нийгэмлэгийн дарга байсан Сакай Осамү гуай анх “Сахалины оюутнуудын найрамдалын төв”-ийн төлөөлөгчөөр зочлон ирснээр бүх юм эхэлсэн билээ. Тухайн үед миний ээж Нагано Миса даргатай анх танилцаж, Сахалины анхны гишүүн болсон юм. Тэгээд ээжийн нөлөөгөөр би ах дүүстэйгээ хамт гишүүнээр элссэн билээ. Мөн би ч бас Косэйкайгийн “Өвөг дээдэстээ мөргөх”, “Эцэг эхээ хайрлах”, “Хүнийг баярлуулах үйл хийх” гэсэн сургаалд татагдсан юм. Гэвч тэр үед орос хэл дээрх судар байхгүй байсан тул би утгыг нь ойлгохгүй ч, япон уншлагаар судраа дуулан уншдаг байв. Бага багаар манай гэр болон ахын гэрт хүмүүс цугларч эхлэн, бүгдээрээ хамтдаа судраа уншдаг болсон. Судрын япон уншлагыг тэр чигээр нь орос үсгээр буулган уншиж, утгыг нь ойлгохгүй ч нэг л онцгой сайхан сэтгэлээр дүүрдэг байсан юм.

Яваандаа Саппорогоос хүн ирж, хичээл зааж өгдөг болсон ба би ч заримдаа сургалтаар Саппоро явдаг болсон. Тэр үед би өөрийнхөө сурсан нэг зүйлээ тэр чигээр нь гишүүддээ дамжуулан заадаг байлаа. Хүмүүс “Гишүүнээр элсэхэд хаашаа хандвал дээр вэ?” гэж асуудаг болсон юм. Манай хотоор дүүрэн оросын том сайхан сүмүүд их байдаг. Орос хүн бол хүний дэргэд өөрийнхөө зовлон бэрхшээлээ тийм ч амар ярьж өгдөггүй тул ээж бид хоёр гишүүд цугларах нийтийн газар байвал зүгээрсэн гэж боддог байв. Тийм ч учраас 2005 онд Южный Сахалин хотын нэгэн оршин суух байранд хозаг нээж чадсан явдалд бид маш их баярласан билээ. Түүнчлэн орос хэл дээр судар болон “Шагжамүнигийн амьсгалын доор” гэсэн ном гарч маш их аз болсон.

Хоза дээр бид голцуу жижүүр, амин өдөр, хоза гэсэн үйл ажиллагаа явуулдаг. Нэг удаа би гэртээ тахих шашны чухлыг тайлбарлаж байхад нэгэн гишүүн: “Нөхрийнхөө сэтгэлийг хүлээн авч, эелдэг харьцаж эхэлсэн чинь хэрүүл маргаан алга болсон” гэж ярьсан юм. Ийнхүү сургаалыг чин сэтгэлээсээ итгэн хүлээн авдаг гишүүдээ улам хайрлаж, үүнээс хойш ч сургаалынхаа тэлээг улам өрнүүлэх зорилготой байна.

Гадаадын сурталчилгаа мэдээ (Yakushin 2008.11)



